

**Төв банкны цахим мөнгөний эрх зүйн үндэс:
Монгол Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийн
эрх зүйн орчныг тодорхойлох нь**

**Legal Foundations of Central Bank Digital Currency: Defining
Mongolia’s Legal Framework of “Legal
Tender” Status**

*Раднаасэдийн Сийлэн**

Хууль зүйн бакалавр (LL.B.).

Монголбанкны Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн,

Улаанбаатар, Монгол Улс.

radnas08@gmail.com



[Товч утга]

Дэлхий дахинд төлбөр тооцоог цахимаар хийх криптовалюта, цахим хэтэвч зэрэг санхүүгийн хэрэгслүүд хурдтай хөгжиж байгаа энэ цаг үед дэлхийн төв банкнууд үндэсний мөнгөн тэмдэгтээ хамгаалах, мөнгөний бодлогын үр дүнг нэмэгдүүлэхээр Төв банкны цахим мөнгийг (Central bank digital currency) судалж, туршиж эхэлжээ. Аливаа төлбөрийн хэрэгсэл “хууль ёсны” гэж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хуульд заасан, Төв банкнаас гаргасан, өөрийн нэрлэсэн үнэ, төлбөрийн үүрэг гүйцэтгэх чадвартай байх г.м олон шинжийг агуулсан байх шаардлагатай байна. Төв банкны цахим мөнгө нь цаасан мөнгөний дижитал хувилбар ч шинэ төрлийн “хууль ёсны” төлбөрийн хэрэгсэл болно. Олон улсад Төв банкны цахим мөнгөний загвар ялгаатай хийгдэж байгаа ч шинэ төрлийн төлбөрийн хэрэгсэл болохын хувьд цаасан мөнгөтэй холбоотой харилцааг зохицуулж ирсэн хуулийн дагуу зохицуулахад бэрхшээлтэй болжээ. Иймд, улс орнууд Төв банкны цахим мөнгөний эрх зүйн үндэслэл, гүйлгээнд гаргах бүрэн эрх, үндэсний мөнгөн тэмдэгтийн шинжийг шинээр тодорхойлж хуулийн шинэчлэлийг хийж эхэлсэн байна. Энэхүү өгүүллээр Төв банкны цахим мөнгөний ойлголт, эрх зүйн үндсийг товч тайлбарлаж, олон улсад хийгдэж байгаа хууль эрх зүйн орчны шинэчлэл, чиг хандлага, Монгол Улсын хууль тогтоомжоор Төв банкны цахим мөнгийг гүйлгээнд гаргах эрх зүйн үндсийг тодорхойлох шаардлагатай эсэхийг товч дүгнэхийг зорив.

[Түлхүүр үг]

Төв банк, үндэсний мөнгөн тэмдэгт, цахим мөнгө, төв банкны бүрэн эрх, шинэ төлбөрийн хэрэгсэл.

I. Оршил

Орчин цагт банк, санхүүгийн салбарын хууль тогтоомж нь эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжилтэй нэг эгнээнд алхах шаардлагатай ч *vice versa* санхүүгийн салбарын хөгжил эрх зүйн хөгжил, хуулийн зохицуулалтад хязгаарлагдах тохиолдол цөөнгүй бий. Нэг талаас энэхүү хязгаарлалтууд нь санхүүгийн салбарын талуудаас илүүтэй хэрэглэгчид болох иргэдийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлын жинлүүрийг тэгш хэмийг хадгалах чухал үүрэг гүйцэтгэх ч нөгөө талаас дэлхий дахинд нэвтэрч буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтаас хоцрогдох эрсдэлийг дагуулдаг гэж үзэж болно. Тухайлбал, цахим гүйлгээ, худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотойгоор төлбөр тооцоонд өргөн хэрэглэгдэж ирсэн цаасан мөнгөн тэмдэгийн хэрэглээ дэлхий дахинд буурсаар байгаа бөгөөд Төв банкуудын зүгээс мөнгөний үнэ цэнийг хадгалах, бодлогын үр нөлөөг сайжруулах зорилгоор Төв банкны цахим мөнгө (ТБЦМ)-ийг судалж, туршиж эхэлжээ. Тухайлбал, 2024 оны эцсийн байдлаар нийт 134 улс ТБЦМ-ний эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөг судалж, 32 улс турших үйл ажиллагааг хэрэгжүүлж, 4 улс гүйлгээнд гаргасан байна.

Монгол Улсад 2017 оноос бэлнээр хийгдсэн гүйлгээний тооны нийт гүйлгээний тоонд эзлэх хувийн жин 29 хувиар буурч байсан бол 2020 оны эцсийн байдлаар 16 хувьд хүрчээ. Энэ нь бэлэн мөнгөний хэрэглээ 2019 онд 3 хувиас доош орсон нь бэлэн мөнгөний хэрэглээ тогтмол багассаар байгааг харуулж байна.

Улс орнууд энэхүү шинэ төрлийн төлбөрийн хэрэгсэл болох ТБЦМ-ийг гүйлгээнд гаргахаас өмнө ТБЦМ-ий мөн чанар, цаасан мөнгөний үед баталж хэрэгжүүлсээр ирсэн хууль тогтоомжид нийцэх эсэх, мөнгөн тэмдэгт нь хуулийн хүрээнд ямар ач холбогдолтой болохыг дүгнэж, хуулийн үндэслэлийг эргэн харах шаардлагыг бий болгожээ. Улмаар, ТБЦМ нь хуульд заасан үндэсний мөнгөн тэмдэгтэд хамаарч болох эсэх, ТБЦМ гүйлгээнд гаргахад хуулийн хязгаарлалтууд байгаа эсэх дүгнэлтийг хийж зарим тохиолдолд хуулийн төслийг боловсруулж эхэлсэн байна.

II. Төв банкны цахим мөнгө гэж юу вэ?

“Төв банкны цахим мөнгө” гэдэг нь төв банкнаас гүйлгээнд гаргасан, төв банкны баталгаатай, аливаа төлбөрийн үүргийг гүйцэтгэх мөнгөний дижитал хувилбар болно. ТБЦМ нь уламжлалт цаасан мөнгийг орлохгүй бөгөөд олон улсад ТБЦМ-ийг мөнгөний бодлогын хэрэгсэл болгон ашиглаж бодлогын

үр дүнг сайжруулснаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангах боломжтой гэж үзэх болжээ. Өөрөөр хэлбэл, ТБЦМ нь цаасан мөнгөний дижитал хувилбар ч шинэ төрлийн “хууль ёсны” төлбөрийн хэрэгсэл болно.


Аливаа төлбөрийн хэрэгсэл “хууль ёсны” гэж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хуулиар тусгайлан заасан, Төв банкнаас гаргасан, өөрийн нэрлэсэн үнэ, төлбөрийн үүрэг гүйцэтгэх чадвартай байх г.м олон шинжийг агуулсан байх шаардлагатай байна. Тэгвэл ТБЦМ-ийг “хууль ёсны” төлбөрийн хэрэгсэл хэрхэн болох тухай хууль зүйн талаас нь оновчтой тайлбарлахын тулд мөнгө, мөнгөн тэмдэгт, “хууль ёсны” мөнгөн тэмдэгт гэх төстэй боловч энэхүү зөрүүтэй 3 суурь ойлголтыг тайлбарлая.

Эдийн засагчид дараах 3 шинж агуулсан хэрэгслийг төлбөрийн хэрэгсэл (*payment instrument*) хэмээн үздэг байна. Үүнд, 1. солилцооны хэрэгсэл байх, 2. төлбөрийн хэмжүүр байх, 3. ханштай байх (цаг хугацааны турш үнэ цэнээ хадгалах) хамаарна. Жишээлбэл, төгрөг нь өөрийн нэрлэсэн үнэтэй (10,000, 20,000 төгрөг), дэлгүүрт ороод бараа худалдан авдаг, өөрийн ханштай тул төлбөрийн хэрэгсэл болно.

Харин төрөөс өөрийн мөнгөн тэмдэгтийг тодорхойлж хуульчлах, үнэ ногдуулах, мөнгөн тэмдэгт гаргах, зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын эрх зүйн байдал, хараат бус байдлыг хуульчлах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Жишээ нь, Улсын Их Хурлаас 1996 онд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хууль ёсны нэгж нь төгрөг байх тухай, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрхийг Монголбанк эдлэнэ гэж заажээ.

Зураг 1.

Мөнгө, мөнгөн тэмдэгт, “хууль ёсны” мөнгөн тэмдэгт



Мөнгөн тэмдэгт буюу *currency* гэдэг нь мөнгөний (*money*) нэг хэлбэр юм. Мөнгөн тэмдэгт нь хуулиар олгосон өөрийн нэрлэсэн үнэ, хэмжих нэгжтэй Төв банкнаас гаргаж буй солилцооны хэрэгсэл юм.

Зураг 1-т дүрсэлснээр мөнгөн тэмдэгт нь мөнгөнөөс явцуу ойлголт бөгөөд мөнгөн тэмдэгт нь хэлбэрийн хувьд биет буюу цаасан мөнгө, зоос, биет бус буюу цахим хэлбэрээр байж болно. Ихэнх улсад мөнгөн тэмдэгтийг хуулиар зөвхөн цаасан мөнгө, зоос байна гэж хязгаарласан байдаг. Жишээ нь, Чили Улсын Төв банкны тухай хуулийн 28 дугаар зүйлд “Төв банк нь цаасан мөнгө, минт зоос гаргах онцгой бүрэн эрх эдлэнэ”¹ гэж заасан бол Японы Төв банкны тухай хуулийн 46.1 дэх хэсэгт² зөвхөн Төв банкнаас гаргасан цаасан мөнгө нь хууль ёсны мөнгөн тэмдэгт гэж заажээ.

“Хууль ёсны мөнгөн тэмдэгт” гэдэг нь аливаа төлбөрийн үүрэг, өр, зээл, санхүүгийн үүргийг гүйцэтгэж болох хуулиар хүлээн зөвшөөрсөн мөнгөн тэмдэгтийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, мөнгөн тэмдэгтэд хуулиар олгодог “онцгой статус” гэж хэлж болно. Төлбөрийн үүрэг гүйцэтгэх агуулга улс бүрийн хууль тогтоомж ялгаатай байх бөгөөд зарим улсад төлбөрийг заавал харилцан тохиролгүйгээр хуульд заасан мөнгөн тэмдэгтээр хийх (татгалзах үндэслэлгүй) байхад зарим улсад “өөрөөр тохиролцсон” бол агуулгын хувьд үүрэг гүйцэтгэсэн гэж тооцож болох зохицуулалт ч байдаг байна.³

Төлбөрийн хэрэгслийн төрлүүдэд цаасан мөнгөнөөс гадна цахим хэтэвчинд хийсэн мөнгө, банк болон бусад санхүүгийн байгууллагаас гаргасан цахим төлбөрийн хэрэгслүүд, криптовалюта нь “хууль ёсны” төлбөрийн хэрэгсэлд хамаардаггүй байна. Хуулийн талаас авч үзвэл Төв банкнаас гаргасан мөнгөн тэмдэгт нь ямар ч үед төлбөрийн үүргийг гүйцэтгэх чадвартай бөгөөд Төв банкны баталгаа ямагт байдаг бол бусад төрлийн цахим мөнгөнд Төв банкны бус тухайн хэрэгслийг гаргасан байгууллагын баталгаа л байна гэж үзнэ. Хэрэв тухайн байгууллага төлбөрийн чадваргүй болж дампуурсан нөхцөлд хэрэглэгч цахим хэтэвчинд байсан мөнгийг нэхэмжлэх, нэхэмжлэл амжилттай болох баталгаа бага байдаг байна. Ийнхүү төлбөрийг гарцаагүй гүйцэтгэж, үүргийг дуусгах шинжээр тухайн улсын Төв банкнаас гаргасан төлбөрийн хэрэгслийг “хууль ёсны” буюу утгаараа “баталгаатай” төлбөрийн хэрэгсэл *legal tender* болгох гол нөхцөл болно. Харин санхүүгийн байгууллагуудаас гаргасан цахим мөнгө, цахим хэтэвч нь хуулиар зөвшөөрсөн бол төлбөрийн хэрэгсэлд хамаарч болох ч хэрэглэгчид зөвхөн тухайн байгууллагын эсрэг шаардах эрх үүсэх, цахимаар хадгалах мөнгөн тэмдэгт бөгөөд Төв банкнаас гаргаагүй тул “хууль ёсны” биш болно. Одоо цагт төлбөр

¹ Basic Constitutional Act Central Bank of Chile, Article 28.

² Bank of Japan Act, 1997.

³ Yoshinaga, Wouter Bossu, Masaru Itatani, Catalina Margulis, Arthur D. P. Rossi, Hans Weenink, Akihiro. 2020. “*Legal Aspects of Central Bank Digital Currency: Central Bank and Monetary Law Considerations.*” IMF. 2020.

тооцоо хийх зориулалтаар гаргасан дээрх цахим санхүүгийн хэрэгсэл нь нэвтрээд удаагүй байгаа шинэ төлбөрийн хэрэгсэлд орох бөгөөд цахим мөнгийг зохицуулж буй хуулийн зохицуулалтаар ТБЦМ-ийг зохицуулахад ашиглах эсэх, нэг ухагдахуун дор төсөөтэй авч үзэх эсэхийг бодлого тогтоогч нар шийдвэрлэх шаардлагатай болно.⁴

Олон улсад ТБЦМ-ийг хуулийн хүрээнд ямар төрлийн мөнгө гэж үзэж байна вэ? Хэрэв цахим мөнгийг одоогийн мөнгөн хөрөнгө болох данс дахь мөнгө, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас гаргасан цахим мөнгөтэй адилтгаж нэг тодорхойлолтод багтаавал нэг хуулийн зохицуулалт дор оршино гэж үзнэ. Цаасан мөнгөтэй харьцуулахад ТБЦМ нь хууль ёсны төлбөрийн хэрэгсэл гэх шинжээр адилхан ч цахим мөнгийг шилжүүлэхэд төлбөрийн дэд бүтэц, систем байх шаардлагатай. Хамгийн гол нь цаасан мөнгийг хэнд ч хэзээ ч шилжүүлж болох ба шилжүүлгийн түүхийг мэдэх боломжгүйгээс гадна хэрэглэгчийн зарцуулалтыг хянах, мэдэх боломжгүй бол цахим мөнгөнд энэ шинж байхгүй байна.

ТБЦМ-ийг арилжааны банкны кредит баланстай харьцуулах боломжгүй юм. Тухайлбал, банкны харилцагчид өөрийн хөрөнгийн шаардах эрх зөвхөн банканд л үүсэх бөгөөд банк ч харилцагчийн өмнө үүрэг хүлээнэ.⁵ Энэ зарчмаар Төв банканд ТБЦМ-ний эзэмшигч бүрт төлбөрийн үүрэг үүсгэх нь (цахим мөнгөний загвараас хамаарах ч) үүргийг хэрхэн гүйцэтгүүлэх, төлбөрийг хэрхэн тооцох нь тодорхойгүй бэрхшээлтэй тул нэг тодорхойлолт дор орших боломжгүй байна. Иймд, ТБЦМ-ийг дээрх 3 төрлийн санхүүгийн хэрэгсэлд хамааруулах нь бэрхшээлтэй тул олон улсад шинэ төрлийн хэрэгсэл гэж тодорхойлж, шинээр хууль батлах эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн шинэчлэлийг хийж байна.⁶

III. Төв банкны цахим мөнгөний эрх зүйн үндэс

Нийгэмд төлбөр тооцооны хэрэгсэл, тэр дундаа мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрхийг тухайн улсын Төв банк эдлэх бөгөөд мөнгөн тэмдэгттэй холбоотой бүхий л зохицуулалтыг зөвхөн хуульд заасны дагуу хэрэгжүүлдэг байна. Хууль тогтоомжийн хувьд эл

⁴ Bank of Canada, et al. “*Legal aspects of retail central bank digital currencies*”, BIS, 2024, 9.

⁵ Frederik Malfrère, “*The role of cash in society and revitalisation of the notion of legal tender*”, 2024, ESCB Legal Conference 2024, 91.

Хувийн эрх зүй талаас цахимаар шилжүүлэг хийхэд харилцагчийн шаардах эрх шилжихгүй ч мөнгө шилжүүлсэн талд шинэ шаардах эрх үүсэж байна гэж үзнэ. Өөрөөр хэлбэл шууд утгаараа хөрөнгө шилжихгүй ч шаардах эрх өөр газар шинээр үүсдэг байна.

⁶ Bank of Canada, et al. “*Legal aspects of retail central bank digital currencies*”, BIS, 2024, 5.

эрхийг Үндсэн хууль, Төв банкны тухай хууль болон бусад хуулиар ялгамжтай зохицуулдаг байна. Жишээлбэл, Польш Улсын Үндсэн хуулийн 227.1 дэх хэсэгт “Польш Улсын Төв банк нь мөнгө гаргах онцгой бүрэн эрхийг эдлэнэ.”⁷ гэж заасан бол Перу Улсын Төв банкны тухай хуулийн 42 дугаар зүйлд “Мөнгөн тэмдэгт, зоос нь төрийн эрхлэх асуудалд хамаарах бөгөөд тус эрхийг Төв банкаар дамжуулан хэрэгжүүлнэ.”⁸ гэж заасан байдаг. Төрөөс мөнгөн тэмдэгт гаргах эрхийг монопол эрх эдлэх нь эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг зохицуулах чухал ач холбогдолтой. Тус зохицуулалтын үзэл баримтлал 19 дугаар зуунд алтны баталгаагаар арилжааны банк мөнгөн тэмдэгт гаргаснаас үүдсэн санхүүгийн тогтворгүй байдал, хямралтай холбоотой гэж хуульч, эдийн засагчид тайлбарладаг.⁹

Олон улсад ТБЦМ-ийг эрчимтэй судалж туршиж байгаа энэ цаг үед ТБЦМ гүйлгээнд гаргах шийдвэр гарсан нөхцөлд нийтээр хүлээн зөвшөөрч хэрэглэгдэх төлбөрийн албан ёсны хэрэгсэл болох тухай хуулийн тодорхой үндэслэлтэй байхыг чухалчилж байна. Харин ТБЦМ-ий эрх зүйн үндсийг тогтооход улс орнууд өөрсдийн хууль тогтоомжийн хүрээнд Төв банк нь ТБЦМ гаргах бүрэн эрхтэй юу? Хууль ёсны төлбөрийн хэрэгсэл байх нь зөв үү? Хуулийн хүрээнд ямар асуудлыг анхаарах шаардлагатай вэ? гэх асуултад хариулж холбогдох дүгнэлтийг хийх шаардлагатай тулна.

Олон улсын валютын сангаас гаргасан ТБЦМ-ий эрх зүйн асуудалд хийсэн судалгаагаар ТБЦМ гүйлгээнд гаргах нь төв банкны тухай хуулиас гадна эрүү, татвар, гэрээний эрх зүй, төлбөрийн систем, төлбөрийн чадваргүйдэл, хувийн мэдээллийн нууцлал, олон улсын хувийн эрх зүй зэрэг олон салбарын хууль тогтоомжийн нийцэл, зохицуулалтыг судлах шаардлагатай гэж дүгнэжээ.¹⁰ Төв банкны эрх зүй талаас ТБЦМ-ийг хуулиар хүлээн зөвшөөрсөн эсэхийг дүгнэхэд Төв банкны зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрхийг хэрхэн зохицуулж буйг анхаарахаар байна. Төв банкны хувьд өөрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон органик хуульд захирагдах бөгөөд тус хуулиар заасан чиг үүргээс давсан арга хэмжээ хэрэгжүүлэх хориотой байдаг. Иймд, шинэ хэлбэрийн төлбөрийн хэрэгсэл гаргах “мандаг” байх нь хамгийн суурь асуудал болно. Мандагтай байна гэдэг нь тодорхой заасан чиг үүрэг болоод зорилтоо хэрэгжүүлэх эрх хэмжээг хэлнэ. Чиг үүрэг буюу *function* нь зорилтоо хэрэгжүүлэхэд “юу” хийх ёстой тухай бол Бүрэн эрх буюу *powers* нь

⁷ The Constitution of The Republic of Poland, 1997.

⁸ The Organic Law of the Central Reserve Bank of Peru (BCRP), 1993.

⁹ Bossu, Wouter, et al. “Legal aspects of central bank digital currency: Central bank and monetary law considerations.” (2020).

¹⁰ Ibid 18.

зорилтоо “яаж” хэрэгжүүлэх тухай зохицуулна.

Төв банкны мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах “мандат” гадаадын улс оронд 3 янзаар хуульчилсан байна. (Bossu W.)

1. Хуульд тусгайлан заасан бүрэн эрх бичигдээгүй ч мөнгө гаргах, зохицуулах чиг үүргийг хуульчилсан,

2. Бүрэн эрхтэй ч, чиг үүргийг тусгайлан заагаагүй,

3. Бүрэн эрх, чиг үүрэг аль алиныг тусгайлан заасан. Энэ тохиолдолд “*lex specialis derogat legi generali*,” зарчмын дагуу аль тодорхой заасныг баримтална.

Олон улсын валютын сан (ОУВС)-ийн дээрх судалгаанд 175 гишүүн улсын мөнгөн тэмдэгттэй холбоотой хуулийн зохицуулалтыг авч үзэхэд 61 хувь нь зөвхөн цаасан мөнгө, зоос гүйлгээнд гаргана гэж заасан бол, 23% хувь нь цахим хэлбэрээр гаргахыг зөвшөөрсөн байна. Үлдсэн 16 хувьд ТБЦМ гаргаж болох эсэх нь тодорхойгүй буюу ерөнхий байдлаар заажээ.¹¹

IV. Олон улсад хийгдэж буй ТБЦМ-тэй холбоотой эрх зүйн шинэчлэл

- Европын холбоо

Түүхийг эргэн үзвэл 1999 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр өнөөдөр санхүүгийн зах зээлд гол байр суурийг эзлэх төлбөрийн хэрэгсэл болох “евро” мөнгөн тэмдэгтийг анх нягтлан бодох бүртгэл болон цахим шилжүүлэг хийхэд ашиглах зорилгоор анх гаргасан байна.¹² Харин өнөөдөр бидний хэрэглэж хэвшсэн цаасан евро, зоос 3 жилийн дараа буюу 2002 онд гүйлгээнд гарч эхэлсэн бөгөөд түүнээс хойш 20 гаруй жилийн дараа цахим мөнгөний хэрэгцээ шаардлага үүссэнтэй холбоотойгоор дахин цаасан мөнгөн тэмдэгтийн эрх зүйн үндсийг дахин хөндөж эхэллээ. Европын холбооны төв банкны 2024 оны тайлангаас харахад “евро” нь биет төлбөрийн хэрэгсэл байхаа больж анх 1999 онд үүсэж хөгжсөн биет бус хэлбэрт шилжих хандлагатай байна.

Дэлхийн томоохон олон улсын байгууллага, төв банкуудын хамтарсан ажлын хэсгийн тайланд¹³ цахим мөнгөний хууль эрх зүйн үндсийг тогтооход анхаарах 4 асуудлыг тодорхойлсон байх ба үүнд, цахим мөнгөний тодорхойлолт, хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах ба эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,

¹¹ Ibid 30.

¹² European Union, ‘The Euro: History and Purpose’, https://european-union.europa.eu/institutions-law-budget/euro/history-and-purpose_en#:~:text=After%20a%20decade%20of%20preparations,changeover%20in%20history%20took%20place.

¹³ Bank of Canada, et al. “*Legal aspects of retail central bank digital currencies*”, BIS, 2024, 9.

холбогдох талуудын эрх, үүрэг, хил дамнасан гүйлгээ хийх зэргийг дурджээ. 2021 оны Олон Улсын Эрүүгийн Шүүхийн шийдвэр¹⁴ болон ТБЦМ-ий хэрэгцээ шаардлага, боломж бий болсноор цаасан мөнгөний үнэ цэнийг хамгаалах, ТБЦМ-ий нийгэмд эзлэх байр суурийг хуулийн хүрээнд нарийвчлан ойлгох хэрэгцээ үүсчээ¹⁵. Дээрх асуудлыг хуульчлан тогтоох хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо хурдацтай хөгжиж буй төлбөр тооцооны дижитал эринд төв банкнаас гаргасан цахим төлбөрийн хэрэгсэл байхгүйгээс үүдэн АТМ машины хэрэглээ буурч, цаасан мөнгөний хэрэглээ, үнэ цэнэ, ач холбогдол буурч, улмаар иргэд төв банканд итгэх итгэлээс гадна еврод итгэх итгэл буурах сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй гэж үзжээ. Одоогийн хэрэгжиж байгаа Европын холбооны суурь гэрээний¹⁶ 128 дугаар зүйлд заасны дагуу зөвхөн Европын төв банкнаас болон тухайн улсын төв банкнаас гаргасан мөнгөн тэмдэгтийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрнө гэж заасан байна. Европын Холбооны 1998 оны 974/98 дугаар зохицуулалтын 11 дүгээр зүйлд¹⁷ мөн дээрх агуулгаар зоосыг хүлээн зөвшөөрөх тухай заажээ. Дээрх заалтаас харахад мөнгөн тэмдэгтийн шинж, хэлбэрийг үгчлэн заагаагүй бөгөөд энэ нь цаасан мөнгө тухайн үед нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хэвшсэн ойлголт байсантай холбоотой байна.

Иймд, Европын комиссоос 2023 оны 6 дугаар сард цаасан мөнгө, зоосыг зохицуулах багц хуулийн төсөл, цахим еврог нэвтрүүлэхтэй

¹⁴ Court of Justice, *Johannes Dietrich and Norbert Häring v Hessischer Rundfunk*, 26 January 2021, Hessischer Rundfunk, C-422/19 and C-423/19, EU:C:2021:63 (hereinafter the ‘judgment in Joined Cases C-422/19 and C-423/19’), <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A62019CJ0422>

Бэлэн мөнгөний хэрэглээ буурсантай холбоотой бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхээс татгалзсан байгууллагын эсрэг гарсан нэхэмжлэлтэй хэрэг. Тус хэргээр төрөөс мөнгөн тэмдэгтийг зохицуулж байгаа зохицуулалтыг шүүхээс тайлбарлаж, хуульд тодорхой бус зааснаар үүдсэн хэрэг хэмээн дүгнэсэн. Төлбөр тооцоог мөнгөөр гүйцэтгэхгүй байж болох нөхцөлийг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзсэн.

¹⁵ The European central bank, “Opinion of the European central bank”, 2023 (CON/2023/34), Official Journal of the European Union, 2023. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:52023AB0034> Европын холбооны гишүүн орнуудын хамтарсан 2010 оны ажлын хэсгийн тайланд анх удаа төлбөрийн хэрэгслийг 1.төлбөрийн үүрэгтэй холбоотой заавал хүлээн зөвшөөрөгдөх, 2.нэрлэсэн үнийн дүнтэй, 3.төлбөрийн үүргээс чөлөөлөх чадвартай гэх 3 шинжийг хангасан бол гэж тодорхойлох оролдлого хийжээ. Тус зөвлөмжөөс харахад “цаасан мөнгийг нийтээр хүлээн зөвшөөрсөн, нэрлэсэн үнийг хүлээн зөвшөөрсөн, төлбөрийн үүргийг тооцох чадвартай” гэж тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл дээрх 3 шинжийг л хангаж, эдийн засгийн эргэлтэд гүйцэтгэх үүргээ биелүүлж байвал төлбөрийн хэрэгсэл, тэр дундаа мөнгөн тэмдэгт нь заавал цаасан байх албагүй гэх санаа агуулна.

¹⁶ Treaty on the Functioning of the European Union, 2012, Article 128.

¹⁷ Council Regulation (EC) No 974/98 of 3 May 1998 on the Introduction of the euro, 1998.

холбоотой 2 эрх зүйн баримт бичгийн төслийг хэвлэн нийтэлжээ.¹⁸ Хуулийн төслийн гол зорилго нь цаасан мөнгийг халах бус цаасан мөнгөний үнэ цэнэ, ач холбогдлыг хадгалахын хажуугаар Төв банкны цахим мөнгийг хамтад нь хөгжүүлж, гүйлгээнд гаргах зорилго харагдлаа. Хуулийн төсөлд туссан зохицуулалтаас дурдвал,

- Хууль ёсны мөнгөн тэмдэгтийн тодорхойлолтыг 2010 оны зөвлөмжид заасан шинжээр тодорхойлох

- Хууль ёсны мөнгөн тэмдэгтийн төлбөрийн үүрэгт тооцохгүй байж болох 2 нөхцөлийг тодорхойлох

- сайн санааны үүднээс *good faith* татгалзсан буюу энэ нь төлбөр хүлээн авагчаас хамааралгүй, үндэслэлтэй, түр зуурын байх

- төлбөрөөс өмнө талууд төлбөрийг бэлэн мөнгөнөөс өөр хэлбэрээр төлж барагдуулахаар тохиролцсон байх

- ТБЦМ-д хууль ёсны мөнгөн тэмдэгтийн статус олгох зэрэг багтана.

- *Бахам Улс*

Бахам Улс нь хамгийн анх ТБЦМ гаргасан улс бөгөөд өөрийн *Sand Dollar*-ийг Төв банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас гаргадаг цахим мөнгөтэй ижил статусаар гүйлгээнд гаргажээ. Бахам Улс 2012 онд баталсан Төлбөрийн системийн тухай хуульдаа өөрчлөлт оруулах замаар Төв банкандаа цахим мөнгө гаргах эрхийг олгожээ. Мөн *Bahamian Dollar Digital Currency Regulations 2021* нь Бахамын цахим доллар нь цаасан мөнгөний цахим хувилбар болохыг зааж, ТБЦМ-ний нарийвчилсан зохицуулалтыг шинэ хууль батлах замаар хийжээ¹⁹. Харин нэр томъёоны хувьд 2020 онд Төв банкны тухай хуульдаа өөрчлөлт оруулж²⁰, Төв банкнаас гаргах мөнгөн тэмдэгтэд цаасан мөнгө, зоосноос гадна “*Төв банкны цахим мөнгө*” гэж нэмжээ.

- *Бүгд Найрамдах Хятад Ардын Улс*

Хятад улс 2020 онд өөрсдийн дижитал юан (renminbi)-ийг гүйлгээнд гаргасан юм. Зарчмын хувьд Хятадын төв банкнаас 2003 онд батлагдан хэрэгжиж байсан Хятадын Ардын банкны тухай хуулийн дагуу ТБЦМ гаргах эрхийг хязгаарлаагүй байсан байна. Харин 2020 оноос хойш цаасан мөнгийг Европын холбооны суурь гэрээгээр зохицуулж ирсэн хуулиар цахим мөнгийг зохицуулахад

¹⁸ European Parliament, “*Proposal for a REGULATION OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL on the establishment of the digital euro*”, COM/2023/369 final, 2023, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0369>

¹⁹ The Bahamian Dollar Digital Currency [BDDC] Regulations, 2021.

²⁰ The Central Bank of The Bahamas Act, 2020.

нэлээдгүй бэрхшээлтэй тулгарсан байна. Иймд, дижитал юанийг нэг мөр тодорхойлж, түүний формат, бүтцийг тогтоохын сацуу хуурамч цахим мөнгөнөөс хамгаалах тухай хууль тогтоомжийг шинэчлэх шаардлагатай болжээ.²¹ Иймд, Хятадын төв банкнаас цахим мөнгөтэй холбоотой зохицуулалтыг зөвхөн Төв банкнаас хийх, ТБЦМ гүйлгээнд гаргах онцгой эрхийг олгож, тус мөнгө нь “хууль ёсны төлбөрийн хэрэгсэл”-д хамаарах тухай хуулийн төслийг боловсруулж байна. Мөн цахим аюулгүй байдлыг хангах, хуурамч мөнгө гаргах нөхцөлд ялын бодлогыг хуулийн төсөлтэй хамтад нь боловсруулж байна.²²

- Швед Улс

2017 оноос судалж эхэлсэн Шведийн и-крона нь тухайн улсын төв банк болох Рискбанкнаас гаргадаг кронагийн цахим хувилбар болно. Рискбанкнаас хийсэн хуулийн дүгнэлтээс харахад Төв банкны тухай хууль болох *Sveriges Riskbank Act* нь цахим мөнгө гаргах нь Төв банкны зорилго, зорилтод нийцэх эсэх, Төв банканд цахим мөнгө гаргах эрх байгаа эсэхийг анхаарсан байна. Тус хуульд Төв банк нь мөнгөний бодлого хэрэгжүүлэх замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах гэсэн зорилтын хүрээнд цахим мөнгө гаргах боломжтой гэж үзсэн ч хуульд тусгайлан заагаагүй байгаа болно. Хэрэв и-кронаг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл гэж хуульд заах нөхцөлд энэ нь санхүүгийн бусад хэрэгсэл болох “цахим мөнгө”, криптовалют зэргээс ялгарч, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, статусын хувьд “хууль ёсны” буюу хаана ч хүлээн зөвшөөрөгдөх ач холбогдолтой болохыг тайланд дурджээ. Мөн и-кронаг хууль ёсны болгох бас нэг арга бол зөвхөн цахимаар төлөгдөж байгаа татварын хураамжийг хийдэг болгох санал ч гаргасан байна. Шведийн Төв банкнаас Retail буюу олон нийтэд чиглэсэн ТБЦМ гүйлгээнд гаргах нөхцөлд хуульд нийцэхгүй тул хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж дүгнэжээ.²³

V. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд цахим мөнгийг хүлээн зөвшөөрсөн эсэх

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль²⁴ нь Улсын Их Хурлаас 1996 онд батлагдаж, өнөөдрийн байдлаар 22 удаа нэмэлт өөрчлөлт

²¹ Lu, L., & Chen, H. (2021). “*Digital Yuan: The Practice and Regulation of China's Central Bank Digital Currency*” (CBDC). Butterworths journal of international banking and financial law, 36(8), 601- 603.

²² Vipin Bharathan, “*People's Bank Of China Draft Law Provides A Legal Basis For Digital Currency Electronic Payments (DC/EP) And Bans All Stablecoins Backed By Renminbi Reserves.*” Forbes, 2020. <https://www.forbes.com/sites/vipinbharathan/2020/10/24/peoples-bank-of-china-draft-law-provides-a-legal-basis-for-digital-currency-electronic-payments-dcep-and-bans-all-stablecoins-backed-by-renminbi-reserves/>

²³ Sveriges Riksbank . E-Krona Pilot Phase 1. 2021.

²⁴ Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, 1996.

орсон байна. Тус хуулиар Монгол Улсын төв банк болох Монголбанкны эрх зүйн байдал, зорилт, чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлохоос гадна үндэсний төлбөр тооцоог хийх мөнгөн тэмдэгтийг тодорхойлсон суурь хуулиудын нэг билээ. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн мөнгөн тэмдэгттэй холбоотой гол зохицуулалт болох 7, 8 дугаар зүйлд заахдаа:

7 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгтийн нэгж, хэлбэр

1. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хууль ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун мөнгөтэй тэнцэнэ.

2. Монгол Улсын мөнгөн тэмдэгт нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хэв загварыг Улсын Их Хурал батална.

8 дугаар зүйл. Төлбөрийн хууль ёсны хэрэгсэл

1. Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн нэрлэсэн дүнгээрээ Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хууль ёсны хэрэгсэл мөн.

2. Төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр төлбөр тооцоонд хэрэглэнэ.”

Дээрх зохицуулалтаас харахад “*төлбөрийн хууль ёсны хэрэгсэл*” буюу *legal tender* нь Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг байх бөгөөд энэ нь 7.2 дахь хэсгээс харахад зөвхөн цаасан болон зоосон биет хэлбэртэй байхаар заажээ. Харин Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.23 дахь заалтад “*«төлбөрийн хэрэгсэл»* гэж бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг Монголбанкны зөвшөөрөл бүхий биет, биет бус хэрэгслийг” хэлнэ гэж заажээ.²⁵ Энэ нь Монголбанкны зөвшөөрөл авсан байх нөхцөлтэй карт, цахим мөнгө хамаарах тул Төв банкнаас гаргадаг үндэсний мөнгөн тэмдэгтэд хамаарахгүй болно. Иймд, ТБЦМ нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8.2 дахь хэсэгт Монголбанкнаас зөвшөөрсөн бусад төлбөрийн хэрэгсэл байж болох ч тус хуулийн 8.1 дэх хэсэгт заасан хууль ёсны хэрэгсэл болохгүй байна. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль нь 1996 онд батлагдсан бөгөөд цахим гүйлгээ төдийлөн хийгдэдгүй, цахим төлбөр тооцооны дэд бүтэц, систем хөгжингүй байсан үед батлагдсан гэдгийг санах хэрэгтэй.

Зорилт, чиг үүрэг, бүрэн эрхийн зохицуулалтыг авч үзвэл:

4 дүгээр зүйл. Монголбанкны үндсэн зорилт

1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

²⁵ Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, 2017 он.

2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

5 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагааны чиглэл

1. Монголбанк энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийн үйл ажиллагааг эрхэлнэ:

1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;

Тус хуулийн 4.1 дэх хэсэгт “үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн” тогтвортой байдлыг хангах тодорхой зорилтыг зааж, 5.1 дэх хэсэгт “*мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;*” чиглэлийг тусгажээ. Тус зохицуулалтаас харахад Монголбанк нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн” тогтвортой байдлыг хангахын тулд “мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;” ёстой байна. Харин ТБЦМ тухайд зорилт, чиглэлийн хүрээнд өргөн утгаараа “мөнгөн тэмдэгт” гэж заасан нь зөвшөөрсөн гэж үзэж болох ч “аяж” хэрэгжүүлэх тухай заасан 7,8 дугаар зүйлээр ТБЦМ гаргах хуулийн үндэслэлгүй байна.

Дээрхээс харахад Монголбанкны үндсэн зорилт, чиглэлтийг одоогийн хэрэгжиж буй Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4.1, 5.1 дахь хэсэгт заасны дагуу өргөн утгаар “мөнгөн тэмдэгт” гэж тодорхойлсон ч мөнгөн тэмдэгтийн хэлбэрийг зөвхөн цаасан, зоосон гэж биет хэлбэрээр тусгасан нь одоогоор ТБЦМ гүйлгээнд гаргах хуулийн үндэслэлгүй байна.

VI. Дүгнэлт

Өнөөдөр дэлхийн аль ч улсад гүйлгээг цахимаар хийж болох бөгөөд цаасан мөнгөний хэрэглээ эрс буурч байгаа нь харагдана. Жишээлбэл, бараа бүтээгдэхүүнийг дебит эсвэл кредит картаас төлж, нийтийн тээвэрт цахим хэтэвч хэрэглэж, ажлын цалинг хүртэл дансаар авдаг үе ирсэн байна. Гэвч цаасан мөнгө нь Төв банкнаас иргэдэд шууд хүрдэг ганц төлбөрийн хэрэгсэл бөгөөд хуулийн хүрээнд Төв банкнаас л олгосон мөнгөн тэмдэгт аливаа төлбөрийн үүргийг дуусгавар болгоно. Мөн цаасан мөнгө нь цахимаар төлбөр хийх боломжгүй иргэд, нийгмийн эмзэг бүлэгт хэрэглэгддэг гэдгийг санах хэрэгтэй.

Ихэнх улс орнууд хуульд ТБЦМ-ийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөх, түүнийг гаргах эрхийг Төв банканд олгохыг дэмжсэн ч техникийн болон нийгмийн бэлэн бус байдал нь Төв банкны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх магадлалтайг ОУВС-с дурдсан байна. Иймд, технологийг дагаж хийгдэх цахим мөнгөний том шилжилтэд аль ч улс хуулийн хүрээнд өөрийн дүгнэлтийг хийж,

бэлэн байх нь цаг хугацааны асуудал бололтой. ОУВС-ийн тайлангаас харахад ТБЦМ-тэй холбоотой хуулийн шинэчлэл, өөрчлөлт нь технологийн араас хийгдэх бус Төв банкнаас ТБЦМ-ийг судлах, хөгжүүлэх явцад хамт судлах, анхаарах шаардлагатай болохыг дурджээ.

Монголбанкнаас олон улс дахь ТБЦМ-ий талаарх туршилтын үр дүн, оновчтой шийдэл бүрэн тодорхой болоогүй учир ойрын хугацаанд ТБЦМ гаргах нь эрт байна гэж дүгнэжээ²⁶. Харин ТБЦМ-ийг гаргах шийдвэрт хүрсэн нөхцөлд тус шийдвэр нь өнөөгийн хууль тогтоомжоор бүрэн эрх, чиг үүрэгт нийцэх ч мөнгөн тэмдэгтийн хэлбэрийг цаасан, зоосон буюу биет хэлбэрээр нарийвчлан заасан нь ТБЦМ гүйлгээнд гаргах нь хуулийн үндэслэлгүй байх бөгөөд үндэслэлийг тодорхой болгох шаардлагатай байна.

²⁶ С.Билгүүнзул, Э.Хосбаяр. “Төв банкны цахим мөнгөний чиг хандлага, үр дүн, анхаарах асуудал”, Монголбанк, Судалгааны товхимол - Олон Улсын эдийн засаг, (2022).

[Ном зүй]

С.Билгүүнзул, Э.Хосбаяр, “Төв банкны цахим мөнгөний чиг хандлага, үр дүн, анхаарах асуудал”, Монголбанк, Судалгааны товхимол (2022).

Bossu, Wouter, Masaru Itatani, Catalina Margulis, Arthur D. P. Rossi, Hans Weenink, and Akihiro Yoshinaga. “*Legal Aspects of Central Bank Digital Currency: Central Bank and Monetary Law Considerations.*” IMF, (2020).

Frederik Malfrère, “*The role of cash in society and revitalisation of the notion of legal tender*”, ESCB Legal Conference (2024)

Yoshinaga, Wouter, BossuMasaru Itatani, Catalina Margulis,Arthur D. P. Rossi,Hans Weenink,Akihiro, “*Legal Aspects of Central Bank Digital Currency: Central Bank and Monetary Law Considerations.*” IMF. (2020).

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, 1992 он.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, 2017 он

Bank of Japan Act, 1997.

Basic Constitutional Act Central Bank of Chile, 1989.

The Constitution of The Republic of Poland, 1997.

The Bahamian Dollar Digital Currency [BDDC] Regulations, 2021.

The Central Bank of The Bahamas Act, 2020.

Council Regulation (EC) No 974/98 of 3 May 1998 on the introduction of the euro, 1998.

Court of Justice, *Johannes Dietrich and Norbert Häring v Hessischer Rundfunk*, 26 January 2021, Hessischer Rundfunk, C-422/19 and C-423/19, EU:C:2021:63 (hereinafter the ‘judgment in Joined Cases C-422/19 and C-423/19’), <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A62019CJ0422>

Lu, L., & Chen, H.. Digital Yuan: The Practice and Regulation of China’s Central Bank Digital Currency (CBDC). Butterworths journal of international banking and financial law, (2021)

Bank of Canada, et al. “Legal aspects of retail central bank digital currencies”, BIS, 2024, https://www.bis.org/publ/othp88_legal.pdf

European Parliament, “*Proposal for a REGULATION OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL on the establishment of the digital euro*”, COM/2023/369 final, 2023, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0369>

Sveriges Riksbank . E-Krona Pilot Phase 1. 2021. <https://www.riksbank.se/globalassets/media/rapporter/e-krona/2021/e-krona-pilot-phase-1.pdf>

Yoshinaga, Gabriel SoderbergMarianne Bechara, Wouter Bossu,Natasha X Che,Sonja Davidovic,John Kiff,Inutu Lukonga,Tommaso Mancini Griffoli,Tao Sun,Akihiro. 2022. “*Behind the scenes of Central Bank Digital Currency: emerging trends, insights, and policy lessons.*” IMF., 2022. <https://www.imf.org/en/Publications/fintech-notes/Issues/2022/02/07/Behind-the-Scenes-of-Central-Bank-Digital-Currency-512174>

[Abstract]

**Legal Foundations of Central Bank Digital Currency:
Defining Mongolia’s Legal Framework of “Legal
Tender” Status**

Radnaased Siilen

Bachelor of Laws (LL.B.)

Ulaanbaatar, Mongolia

In response to the rapid development of digital payment instruments such as cryptocurrencies, e-wallets global central banks have started to research and experiment their own digital currency, also known as Central bank digital currency (CBDC) for the reasons of protecting national currency and ensuring the effectiveness of monetary policy. A currency enjoys a “legal tender” status, if the law specifies its mandatory acceptance, at full face value, with the effect of discharging monetary debts issued by the central bank. Even though Central bank digital currency is a digital version of the paper banknotes and coins, it is still a new type of payment instrument. Although various approaches are being taken in the design and development of central bank digital currencies, as a new type of payment instrument, it has become challenging to regulate it under the laws that had been tailored for physical forms of money. Today we are witnessing efforts of multiple countries to reassess their current legal foundations of Central bank digital currency by redefining of “legal tender” and the central bank’s power to issue currency by taking steps toward amending existing regulations. This article aims to briefly explain the characteristics of Central bank digital currency, international efforts to reform its legal environment, and predetermine whether current Mongolian legislation has the right to issue Central bank digital currency.

[Keywords]

Central bank, national currency, digital currency, central bank power, new payment instrument.